



VII-IX/2021

Тархаасан: 2021 оны 11 дүгээр сарын 12



## Барилгын өртөг өмнөх улирлаас 3.5 хувиар өссөн байна


Барилгын өртгийн ерөнхий индекс (2015=100) 2021 оны 3 дугаар улиралд 179.8 болж, барилгын өртөг өмнөх улирлаас 3.5 хувь, өмнөх оны мөн үеэс 35.4 хувиар өслөө.

Харин орон сууцны барилгын өртгийн индекс (2015=100) 2021 оны 3 дугаар улиралд 203.1 болж, барилгын өртөг нь өмнөх улирлаас 3.8 хувь, өмнөх оны мөн үеэс 35.4 хувиар өссөн байна. Орон сууцны барилгын өртөг өмнөх улирлаас 3.8 хувиар өсөхөд машин механизмын түрээсийн зардал 8.9 хувь, материалын өртөг 2.2 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Орон сууцны бус барилгын өртгийн индекс (2015=100) 176.3 болж, өртөг нь өмнөх оны мөн үеэс 36.3 хувь, өмнөх улирлаас 3.6 хувиар өссөн байна. Орон сууцны бус барилгын өртөг өмнөх улирлаас 3.6 хувиар өсөхөд эмнэлэг, сувиллын барилгын өртөг 5.5 хувь, конторын барилгын өртөг 2.2 хувиар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Инженерийн барилга, байгууламжийн өртгийн индекс (2015=100) 142.8 болж, өртөг нь өмнөх оны мөн үеэс 19.2 хувь, өмнөх улирлаас 0.5 хувиар өссөн байна. Инженерийн барилга, байгууламжийн өртөг өмнөх улирлаас 0.5 хувиар өсөхөд авто замын байгууламжийн өртөг 0.6 хувь, эрчим хүчний байгууламжийн өртөг 0.3 хувиар өссөн нь нөлөөлжээ.

ЗУРАГ 1. БАРИЛГЫН ӨРТГИЙН ИНДЕКС (2015=100), улирлаар, хувь



## ХҮСНЭГТ 1. БАРИЛГЫН ӨРТГИЙН ИНДЕКС, дэд салбараар, хувиар

Дэд салбар	2021 VII-IX 2015	2021 VII-IX 2020 VII-IX	2021 VII-IX 2021 IV-VI
	2015=100		
<b>Ерөнхий индекс</b>	<b>179.8</b>	<b>135.4</b>	<b>103.5</b>
Орон сууцны барилга	203.1	135.4	103.8
Орон сууцны бус барилга	176.3	136.3	103.6
Инженерийн барилга, байгууламж	142.8	119.2	100.5

### Ойлголт, тодорхойлолт:

Барилгын өртгийн индекс: Барилга, байгууламжийг барьж байгуулахад зарцуулж буй барилгын материал, машин, механизм, цалингийн үнийн өөрчлөлтийг илэрхийлнэ.

Барилгын төрөл: Барилгын төрлийг орон сууцны барилга, орон сууцны бус барилга, инженерийн барилга, байгууламж гэж хуваана.

### Тооцох аргачлал:

Барилгын материал, цалин, машин, механизмын жинг тооцон, сонгогдсон барилгын материалын үнэ, машин, механизмын тариф, цалинг цуглуулж, тус бүрийн индексийг тооцно. Индексийг тооцоходоо Ласпейрсийн үнийн индексийн томъёог ашиглана.

$$I_1 = \frac{\sum P_1 Q_0}{\sum P_0 Q_0}$$

$P_0$  - суурь үеийн үнэ,

$P_1$  - тайлант үеийн үнэ,

$Q_0$  - суурь үеийн тоо, хэмжээ



### Эх үүсвэр:

ҮСХ, Барилгын өртгийн мэдээ

### Ангилал, код:

ЭЗҮАСА, БНА

### Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

### Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 2 дугаар сарын 15

Эдийн засгийн статистикийн газрын  
дарга А.Дэмбэрэл  
Утас : (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн газрын Үнийн  
статистикийн хэлтсийн статистикч  
Т.Жигжидсүрэн  
Утас : (976-51)-261559



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212